



## The Contribution of Commander Subedei to the History of Mongol Military Art

Shijee Palamdorj

*Sc.D., Professor, Leading researcher, Center for military art, Defense Research Institute of Mongolia*

*E-mail address: [Palamdorjsh1948@gmail.com](mailto:Palamdorjsh1948@gmail.com), ORCID:0009-0008-6114-1698*

Received: 15 February 2026

Revised: 15 March 2026

Accepted: 25 March 2026

Published online: 30 March 2026



### ABSTRACT

*Subedei, son of a blacksmith from Urianhai named Zarchiudai and younger brother of Zelme, began his service to Genghis Khan and was later appointed Prince of the Thousand and participated in numerous campaigns for the survival of the Great Mongol Empire. This article will present his contribution to conquering enemies through strategies and tactics of stealth infiltration, ambush and maneuver, pursuit, and discuss the results of these. The article will present his achievements based on sources, research papers, and numerous literary works.*

**Keywords:** *commander Subedei, strategy and tactics of victory over the enemy: pursuit, maneuver, ambush war.*

## Монголын цэргийн урлагийн түүхэнд Сүбээдэй жанжны оруулсан хувь нэмэр

Шижээ Паламдорж

*Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Цэргийн урлаг судлалын төвийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор*

*[Palamdorjsh1948@gmail.com](mailto:Palamdorjsh1948@gmail.com), ORCID:0009-0008-6114-1698*

### ХУРААНГУЙ

*Урианхай төмрийн дархан Зарчиудайн хөвүүн, Зэлмэ-ийн дүү Сүбээдэй Чингис хаанд хүчин зүтгэж эхэлсэн ба хожим нь мянганы ноёноор томилогдож, Их Монгол Улсаас оршин тогтнохын төлөө хийсэн олон аян дайнд оролцжээ. Тэрээр дайснаа ялан дийлэхдээ мөрдөн мөшигх, гээгэ даран нэхэн байлдах, аялан дайтах стратеги, тактикаар дайсныхаа цэргийг буулган авч байсан тухай болон ямар үр дагавраар төгсөж байсан болох талаар түүний оруулсан хувь нэмрийг сурвалж болон судалгааны бүтээл, олон ном зохиол дахь баримт, нотолгоогоор илэрхийлсэн өгүүлэл болно.*

**Түлхүүр үгс:** *Сүбээдэй жанжин, дайснаа ялан дийлэх стратеги, тактик: мөрдөн мөшигх, гээгэ даран нэхэн байлдах, аялан дайтах.*

### Оршил

Их Монгол Улсын цэргийн алдарт жанжин **Сүбээдэй** (1176-1246/1248)-н 850

жилийн ой өнгөрсөн онд болж өнгөрлөө. *Сүбээдэй* жанжны оролцсон, удирдсан аян дайны талаар түүхэн сурвалж [МНТ; Рашид Ад Дин I, II, III боть; М.Жувейни. Дэлхийг байлдан дагуулагчийн түүх. 2006; Чжао Хун. Монгол татаарын бүрэн тэмдэглэл. 2005; Пэн дая, Сюй Тин. Хар татаарын хэргийн товч. 2005; Марко Поло. Орчлонгийн элдэв сонин. 1987; Юан улсын судар; гэх мэт], судалгааны бүтээл олон бүтээлд тэмдэглэн бичсэн нь их ч Их Монгол Улсын цэргийн урлаг (стратег, тактик)-т чухамхүү ямар стратеги, тактикийн ажиллагаагаар өөрийн хувь нэмрийг оруулсан болохыг онцлон илэрхийлсэн нь бүрхэг байгааг тодруулан илэрхийлэхэд энэхүү өгүүллийн зорилго, агуулга чиглэсэн болно. Тэгэхдээ *Сүбээдэй* жанжны оролцсон, удирдсан аян дайн стратеги, тактикийн ажиллагаанд түүний санаачилсан, хэрэгжүүлсэн стратеги, тактикийн ажиллагааг түүхэн баримтад тулгуурлан тайлбарлан өгүүлэх нь бидний өгүүллийн зорилт болно. Судлаач бид Их Монгол Улсын цэргийн урлагийг судлаад түүний “ялалтын эх сурвалж нь монголын хөнгөн морин цэргийн хөдөлгөөнт чанар, маневрын урлаг, тэр үеийн монгол цэргийн хат, эр зориг, зэвсгийн хүч чадал, монголын цэргийн жанжнуудын сэтгэлгээний өндөр чадвар зэрэгт оршиж байжээ” (*Ш.Паламдорж 2006*) гэж үзээд түүнийгээ тайлбарлан илэрхийлэхийг хичээдгийн нэгэн илрэл нь энэхүү өгүүлэл болой. *Сүбээдэй* жанжны оролцсон, удирдсан аян дайны талаар нэлээд судлаачид (*Х.Шагдар 2019*) бүтээл туурвилдаа бичсэн нь өргөн дэлгэр ч аян дайны түүхээр зонхилдог. Тэр тусмаа гадаадын судлаачид Чингис хааны цэргийн урлаг дахь стратеги, тактикийн зааг, ялгааг, тэдгээрийн бэлтгэл, эхлэл, өрнөл, төгсгөлийн динамикийг задлан тайлбарласан нь ховор юм. Манай цэргийн мэргэжилтнүүдийн бакалавраас дээш мэргэжилтэй хүмүүсийн зонхилох хэсэг нь оросын цэргийн сургуультай, өөрийн цэргийн түүхийн мэдлэгээр дутмаг байдал нь Их Монгол Улсын цэргийн урлагийн гүнд орж судлах боломжоор хязгаарлагдмал байгааг харгалзан Монголын үндэсний цэргийн урлагийн түүхэнд *Сүбээдэй* жанжны оруулсан хувь нэмрийг онцлон илэрхийлэх нь танин мэдэхийн төдийгүй, өөрийн цэргийн урлагийн онол, практикийг хөгжүүлэхэд ач холбогдолтой байх болно хэмээн үзэж байна.

*Судалгааг явуулсан арга, арга зүй:* “Их Монгол Улсын цэргийн урлаг” хэмээх нэг сэдэвт бүтээлээ (*Ш.Паламдорж 2006*) туурвин хэвлүүлснээс хойш хорин жил өнгөрчээ. Түүнээс хойш цэргийн түүх, байлдах урлагтай холбоотой сурвалж, судалгааны бүтээлийн тоо, уншиж судалсан минь ч нэмэгдэж, түүхэн судалгааг арай гүнзгийрүүлэн судлах түүхийн арга, герменевтик, диалектик арга зүйг ашиглах боломж дээшилсэн зэрэг нь энэхүү өгүүллийг бичих үндсийг бий болголоо. Цэргийн урлагийн түүх бол зөвхөн түүхэн баримт дээр, аян дайны түүхэн сурвалжид үндэслэгддэг болохыг эртний Римийн философч, улс төрийн зүтгэлтэн, зохиолч Цицероны “түүх бол тухайн эрин үеийн гэрч, үнэн худлын гэрэл, амьдрал, тэмцлийн дурсгал” гэсэн алдарт үгийг эш татъя. Их Монгол Улсын цэргийн урлагийн түүхээр бичсэн маш олон тайлбар, гаргалгаа, нотолгоо их ч, үнэн бодитой нь нэг л байгаа. Түүнийг монголын ахуй амьдрал, зан үйл, авир үйлдэл, түүн дотор өсөж торнисон, сэтгэлгээ нь түүгээр хөгжсөн монголын цэргийн урлаг судлаачид л илүүтэй илэрхийлж чадна.

*Монголын цэргийн урлагийн түүхэнд Сүбээдэй* жанжны оруулсан хувь нэмрээр явуулсан судалгааны үр дүнг: бид нэн хураангуйлахдаа хэд хэдэн цуврал

өгүүллээр илэрхийлэх болно. Цэргийн урлаг бол зөвхөн аян дайны явц, төгсгөлөөр илэрхийлэгддэггүй, өргөн хүрээтэй судлагдахуун юм. Цэргийн урлаг аян дайнд бэлтгэх (зохин байгуулах, төлөвлөх); дайснаа болон өөрийн боломж, чадавхыг болон байгаль, цаг уурыг үнэлэх; аян дайныг явуулах бодлого, стратегийн ажиллагаагаа тодорхойлох; зам маршрут, маневраа аян дайны чиглэлийг тогтоох; холбоо зохион байгуулалтаа шийдвэрлэх; удирдлага, бүх талын хангалтын үйл явц зэрэг олон асуудлыг багтаадаг (*Ж.Базарсүрэн et al. 2014, т.359-360*) тул энэ бүгдээр илэрхийлэгдэнэ. Их Монгол Улсын цэргийн урлаг бол монголчуудын ахуйгаас үүссэн, байгаль, нийгмийн хуульд зохицсон үйлдэл, үйл ажиллагааны цогц үр дүн юм (*Ш.Паламдорж 2022, т.21*). Энэ удаад бид зөвхөн Сүбээдэй баатар дайснаа ялан дийлэхдээ мөрдөн мөшгих, гэзэг даран нэхэн байлдах, аялан дайтах стратеги, тактикаар дайсныхаа цэргийг буулган авч байсан тухай болон ямар үр дагавраар төгсөж байсан болох талаар түүний оруулсан хувь нэмрийг сурвалж болон судалгааны бүтээл, олон ном зохиол дахь баримт, нотолгоогоор илэрхийлж болно.

Чингис хаан түүний цэргийн жанжнууд дайсан улстай дайтахыг урьдал болгож байгаагүй (*Монголын нууц товчоо 2007, §235, §239*) бөгөөд эхлээд найрамдах, дагаар оруулах, хамтрахыг чухалчилж байв. Тэд саналаа элч төлөөлөгчөөрөө дамжуулдаг байсан бөгөөд саналаас нь татгалзсан (*Рашид-ад-Дин 2002а, т.271*), тэднийг нь баривчилж алсан (*Монголын нууц товчоо 2007, §235*), хариу өгөхдөө “их үгээр” доромжилсон, татгалзсан (*Монголын нууц товчоо 2007, §256*) тохиолдолд л аян дайныг явуулдаг (*Монголын нууц товчоо 2007, §256; Рашид-ад-Дин 2002а, т.340, 367*) байжээ.


Аян дайнд бэлтгэх, түүнийг явуулахад цэргийн жанжнууд онцгой үүрэг гүйцэтгэж байсны нэг нь Жарчуудай өвгөний хөвүүн **Сүбээдэй баатар** юм. Урианхай дархан Жарчуудай өвгөн Тэмүжинд “... эмээлээ тохуул, үүдээ сахиул” (*Монголын нууц товчоо 2007, §97*) хэмээн Зэлмийг, хожим нь **Сүбээдэйг** нөхөрлүүлэхээр өгчээ.

Тэмүжинг гурван Мэргэдэд мөрдүүлж, Бурхан халдун уулнаа бүгэж, амь аврагдаж байсан үеэс Сүбээдэй төрсөн ах Зэлмэ (*Монголын нууц товчоо 2007, §103*) Тэмүжингийн, хожим нь Их Монгол Улсын эзэн хаан Чингисийн амь нас, алдар гавьяаг хамгаалагч, хамтрагч нь болсон бөгөөд аян дайны их стратеги, тактикийн ур ухаанд дүүгээ сургажээ.

#### ***Сүбээдэй жанжин хэрхэн оролцож байсныг түүхээс харвал:***

**Нэг.** 1203 оны намар Хэрэйд улсыг эзэлсний дараа Монгол нутагт хоёр том улс үлджээ. Ван ханыг дагаж явсан Жамуха тэргүүтэй Хатагин, Салжиуд, Дөрбэн, Тайчиуд, Хонгирад зэрэг олон монгол овог Найманг дагажээ. Таян хан, хаан болохыг санаархаж, “тэнгэрт нар сар байдаг, газарт хоёр хаан хэрхэн байж болох?” би явж Хамаг Монголыг авч ирье хэмээжээ. Найманы Таян хантай нийлсэн Жамух нарын цэрэгтэй дайтахаар Халхын ор нугын хэлтгий хаднаас морилж (*Монголын нууц товчоо 2007, §192*), “Хар ус нуураас холгүй орших Ховд голд” (*Ренэ Груссе 2004, т.29*) Таян ханы цэрэгтэй байлдаж, түүнийг хөнөөжээ. Тэмүжин өөрийн цэргийг дараах журамд оруулан байлджээ. Зэбэ, Хубилай хошуучилж (*Монголын нууц товчоо 2007, §193*), “Чингисийн шилдэг өрлөгүүд Мухулай, **Сүбээдэй**, Зэвийн хүчирхэг гурван бүлэг цэрэг явна. Дараа нь их цэрэг

мөн л төв, баруун, зүүн жигүүр хэмээх гурван хэсэгт хуваагдан урагшилна” (*Михаэл Правдин 2005, т.80*).



**Зураг 1.** Найманы Таян хааны цэрэгтэй Тэмүжингийн цэрэг байлдсан байлдааны журам.

Манлай цэрэг бол байлдаанд болон аян замд гол хүчний өмнө байрладаг цувраа цэрэг бөгөөд аяны цувааны тэргүүнд хошуучлан явж, дайсантай тулгарсан нөхцөлд бие даан байлдах чадамжтайгаараа зохион байгуулагдаж, тухайн цагийн байдал, хүн хүчний харьцаанаас шалтгаалан дайсанд гэнэтийн цохилт өгч няцаах юмуу гол хүчээ иртэл саатуулан барих, эсвэл эсрэг этгээдийн бөөгнөрсөн цул хүчийг сарниаж цувруулан бутаргах зорилгоор амсхийх зав өгөлгүй өдөөн хатгалдаж, зохистой газарт отон бүгсэн гол хүчиндээ хүртэл хуурмагаар ухарсаар дайснаа тал талаас нь бүслэн хаах, таслан цохих нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй байжээ ... (*Ж.Базарсүрэн et al. 2014, т.183*). Үүнээс харахад, Их Монгол Улс байгуулахын төлөөх Чингис хааны тэмцэлд *Сүбээдэй манлай цэргийг удирдах арга ухаанд суралцсан байжээ.*

**Хоёр.** Өштөн дайсан болох Мэргэдийн Тогтога бэхитэй Чингис хаан хулгана жил (1204 он), Хар талын үзүүрт байлдаж, Саар хээрт ард иргэд, улсыг нь дагуулав (*Монголын нууц товчоо 2007, §196*). Чингис хаан үхэр жил (1205 он), Тогтога бэхийн хөвүүд Худу, Гал, Чулуун нарыг нэхүүлэхээр *Сүбээдэйг илгээхэд* тэрээр цэрэглэн мордов. Чингис хаан: “Чамайг явуулахдаа би өчүүхэн цагт ... гурван Мэргидийн Удайдад Бурхан халдунд гурвантаа бүслүүлж айлгагдлаа, би. Тийм өстөн иргэн эдүүгээ ... одов”, “... хөвгүүдийг гартаа оруулваас, бидэнд авчрах хэрэг юун буй?” (*Монголын нууц товчоо 2007, §199*) хэмээсэн зарлиг ёсоор Чүй мөрнөө хүрч тэднийг Сүбээдэй мохоожээ (*Монголын нууц товчоо 2007, §236; Рашид-ад-Дин 2002а, т.319*). Сүбээдэйгээр энэ үйл хэргийг бүтээсэн нь ямар чухал ач холбогдолтой болохыг Чингис хааны захиас гэрчилдэг (*Монголын нууц товчоо 2007, §199*).

Энэ үеэс хойш *Сүбээдэй дайсан этгээдийг мөрдөн мохоох, аялан дайтах үйлсэд олонтоо томилогдох болжээ.*

**Гурав.** Найманы угсаа залгамжлагч хун тайж “Хүчлүг монголчуудад цохигдож зугтаад Хар Хятанд очиж хааны гүнжтэй гэрлэжээ. Хааныг нь үхүүлсний дараа

Хар Хятаны хаан ширээг эзлэн суужээ. Зөвд баруун хойд зүгийнулс орнуудыг харьяалуулж, ... зах хязгаар нутгийг түйвээж асан мэргэдүүдийг сөнөөхийг тушаахдаа арга мэх ихтэй өрлөг **Сүбээдэйг** ерөнхийлөн захирагчаар томилжээ. ... Зэвийн цэрэг Хүчүлүгийг Памирын уулсын хавцлаар хөөж барьж авчээ” (*Михаэл Правдин 2005, т.98*).

**Дөрөв.** Их Монгол улсын их хаад Алтан улстай байлдахад **Сүбээдэйн оролцсон** түүхийг бид хоёр хуваан үзэж болох юм. *Нэгд*, Чингис хаанаас Алтан улстай дайтахад оролцсоны; *хоёрт*, Өгээдэй хаанаас Алтан улстай дайтаж мөхөөхөд оролцсоных гэж.

Чингис хаан 2011 оны хавар, аян дайн хийхээр Алтан Улсыг зорихдоо цэргээ хоёр замд хуваажээ. Зэв, Мухулай, **Сүбээдэй** нарын захирсан манлай цэргийг баруун зам болгов. Энэ замын цэрэг Хэрлэн голын эхээс Алаша уулын зүүн хормойгоор 800 км зам туулан Тангуд оржээ. Энэ оны 4 дүгээр сар гэхэд баруун замын цэрэг “Зүрчдийн нутагт цөмрөн Да Шюлян, Пянли-г дараалан аваад зун нь Датунд орох оньс гэгдсэн Үсэпу-г довтлов” (*Х.Шагдар et al. 2024, т.82*).



**Зураг 2.** Чингис хааны цэрэг анх 1211 онд ачлан дайтсан нь (*Х.Шагдар et al. 2024, т.83*).

Дараа нь Үнэгэн даваанд Мухулайн манлай цэргийн цохилт өгөв. Алтан улсын цэрэг Үнэгэн даваанаас ухармагц монголчууд үүр цайтал үлдэн хиар цохиж Сюань дэ-д оруулжээ. Үнэгэн давааны их тулалдаанд ялж, Жундууд тулж очжээ. Ингээд цэргээ олон замд салгахдаа “Алчи ноён **Сүбээдэй** нарын жолоодсон зүүн замын цэргийг Киданы нутаг - Ляодун өөд томилжээ. Энэ үед киданчуудыг толгойлон хөдөлгөж чадах нөлөө бүхий хүн бол Алтан улсын хойд хилийн түмэн цэргийн жанжин Елюй Люгэ л байжээ. Дайсны нутаг дундуур туулж түүнд хүрэх тул **Сүбээдэй** нар төлөөлөгчийн журмаар цөөн цэрэг авч аливаа тулгаралт

мөргөлдөөнөөс зайлсхийн өдөр бүгэж, шөнөөр аялаж явсаар 1211 оны 12 дугаар сар орчимд Монголын хилээс Жунду орчмоос 6 хоногийн зайтай орших Лууха (Лаохахэ) голын дээд урсгалд хүрч Елюй Люгэтэй уулзжээ” (*Д.Сайшаал 1987, т.702*). Люгэтэй Алтан улсыг хүч хавсран байлдах гэрээ байгуулан, Люгэ цэрэг цуглуулж Ляодун орчмыг байлдах, монгол зүүн замын цэргээрээ түүнд туслахаар тохирч цаг болзоод Чингис хааны төлөөлөгчид эргэн иржээ. Чингис хаан “*Сүбээдэйг* Чин гүрний уугуул нутаг Манжуурт тандуулахаар явуулахад ... *Сүбээдэй* Манжуурыг хөндлөн гулд хэрэн байлдаж далайн эрэгт хүрээд эргийн дагуу өмнө зүйг явж Солонгосын хааныг Чингис хааны харьяад оруулав” (*Михаэл Правдин 2005, т.92*). Алтан улстай 2011-2015 онд явуулсан аян дайны явцад *Сүбээдэй нар Ляодунг Алтан улсаас үндсэнд салгаж, улмаар Солонгостой найрамдлын гэрээ байгуулан, Алтан улсыг хойд хилийн вассалаас салгасан байна.*

**Тав.** Найрамдахаар илгээсэн элч нарыг нь хөнөөсөн Сартуултай дайтахаас өөрцгүй болсон тул “Чингис хаан Алтан улстай хийх дайныхаа эрчмийг Мухулайд, Монгол дахь говиос хойших хэргийг Отчигин ноёнд (*Монголын нууц товчоо 2007, §257*), говиос урагшийг гинж Алага бэгид хариуцуулаад, 10-12 түмэн цэрэг цуглуулан “2019 оны 5 дугаар сард Эрчис мөрөнд хүрч зусаж, султан Мухаммедэд элч заран султаны эсрэг хандаж, наймаачдыг үхүүлсэн гэх мэт зүйлийг дурдан өшөөгөө авахын тулд түүнтэй байлдахаар шийдсэн тухайгаа болон дайлаар хөдөлснөө мэдэгдсэн байна” (*Рашид-ад-Дин 2002а, т.339*). Энд Уйгарын идүүд хамсаатныхаа хамт, Алмалынхаас Суктак бэхи, Харлугийн цэрэг ирж нийлжээ (*Рашид-ад-Дин 2002а, т.339*). Сартуултай явуулсан аян дайнд Чингис хаан хоёр замын цэрэг томилон илгээжээ. Нэгд, Зэв, *Сүбээдэй*, Тогучар нарт тус бүр нэгэн түмэн цэрэг өгч “Зэвийг магнайд, *Зэвийн гээзгт Сүбээдэйг, Сүбээдэйн гээзгт хүргэн хүү Тогачур ноёныг илгээв*” (*Монголын нууц товчоо 2007, §257; Рашид-ад-Дин 2002а, т.319*). Энэ дайнд “Зэбэ, *Сүбэгээдэй*, Тохучар гурав Жалалдин султан Хан мэлиг хоёрын хойноос орж, жич тэднийг хядаад, Бухар, Сэмисгаб (Самарканд), Удуар (Отрар) балгасанд тэднийг үл нийлүүлэн дарж, Шин мөрөн хүртэл үлдэн хөөж явахад ... Жалалдин султан Хан мэлиг хоёр амиа хоргоон, Шин мөрөн өөд тутаав”. Хоризмын гүрнийг эцгээсээ өвлөн авсан Лалын газрыг их эзэн гэгдэх Хоризмын шаг Ала эд дин Мухамед захирч, Хорезмын шагийг хөнөөх нь Чингис хаанд бүхнээс илүү хэрэгтэй байжээ. Шагийг нэхэн одогч арга залт төгс *Сүбээдэй*, эрэлхэг шаламгай Зэв нар түүний мөрийг алдалгүй мөшигсөөр Каспийн тэнгис тулгажээ. Ала эд дин Мухамед Каспийн тэнгисийн эзэнгүй бяцхан “Абис хун” хэмээх (*Алтан-Очир 2020, т.163*) арал дээр үхжээ. Шаг алга болсон тухай мэдээг *Сүбээдэйн* элч авчирч өгчээ. “Чингис хаан Зэбэ, *Сүбэгээдэй* хоёрыг маш соёрхожээ” (*Монголын нууц товчоо 2007, §257*). Чухамхүү энэ үеэс хойш *Сэбээдэй баатар нэхэн дайтах, аялан дайтах арга ухааныг төгс эзэмшиж* олон удаа гайхамшигт ялалтыг байгуулах болжээ.

**Зургаа.** Чингис хаан *Сүбээдэйг* дуудаж, Хоризмын шагийг хөөж тэр улс гүрнийг хөндлөн гулд тууулж үзэж харсаныг асуухад, Хорасаны тухай, хүчирхэг хана хэрэм бүхий Херат, Мерв, Нишاپүр хотуудыг дурдав. *Сүбээдэйн* энэ айлтгал аян дайны цаашдын явцыг шийджээ. Чухам энэ үеэс Оросын хэдэн зуун жил Их Монгол Улсын харьяат байх, Зүүн, Өмнөд Европын улс орнуудын аймшиг, аюул

доор амьдрах үүд хаалга нээгдсэн ажээ. Чингис хаан “Сүбээгэдэй баатрыг умар тийш Ханлин, Кибчагууд, Бажигид (Башкир), Оросууд, Мажарууд, Асуд, Сасуд, Сэркэсүүд (Хиргис), Кэшимир, Болар (Болгар), Рарал (Кэрэл), эдгээр арван нэгэн аймаг харь иргэнд хүртэл Идил (Ижил), Жаяг (Урал) ус мөрөн гэтэлж, Кивамэн (Киев) Кэрмэн балгасанд хүртэл аялуулав (*Монголын нууц товчоо 2007, §262*). Сүбээдэй баатар Орос, Европын улсуудын түүхэнд хийсэн аян дайнаараа олон ном зохиолд тэмдэглэгдсэн байдаг. Энэ аян дайны тухай эс өгүүлж, зөвхөн **Сүбээдэй** баатар дайсан улсын тэргүүн нарыг мөрдөн мөшгих, гээг даран нэхэн дайтах, аялан дайтаж буулган авч байсан нь ямар зорилго агуулж байсан болохыг дурдъя. Энэ нь **нэгд**, дайсагнагч улсын тэргүүн, түүний үр сад нь ялагдаж “өт хорхойн адил болсон ч яваандаа могой болж улс гүрний дайсан болно” гэсэн Чингис хааны үзэл бодлын дагуу явагдаж байжээ. **Хоёрт**, толгойлогч тэргүүнээ алдсан аль ч улсын ардууд дуулгавартай болдог тэр үеийн нийгмийн зүй тогтолыг Их Монгол Улсын хаад, ноёд мэддэг байжээ. **Гуравт**, тухайн цаг үеийн эзэн, тэргүүн нар нь ард түмнээ орхин хар амиа бодон дүрвэдэг байсантай холбоотой ажээ.

Өгөөдэй хаанаас Алтан улстай хийсэн аян дайнд оролцож байсан түүхэн баримт их, түүнд Сүбээдэй баатар хэрхэн оролцсоныг цухас дурдвал:

**Долоо.** Өгөөдэй хаан ширээн (1229.ҮШ.)-д суумагцаа Алтан улсыг дайлах бэлтгэлийг хангаж эхэлжээ. **Сүбээдэй** “Тун гуань боомт”-ын баруун өмнөх бага Тун гуанийг эзлэхээр богино аянаар алгинчлан байлдан тагнаж, Циньлин уулын араар Нанжинд дөхөх чиглэлд Алтан улс асар их хүчээ хуримтлуулсан болохыг баттай тогтоожээ. **Сүбээдэй**, Чингис хааны сүүлчийн гэрээсийг санав. Түүний сэтгэлийн нэгэн зовнил бол Чин (Алтан) улсаас болгоомжлох явдал байсан учир үхлүүт хэвтэж байхдаа Тулуйд Чин улсыг дахин дайлахыг захихдаа “Тэдний шилдэг сайн цэрэг эрс өрнө газар байна. Умар талд нь Шар мөрөн. Өмнө, өрнө талд өндөр уулс хааж буй тул тэд дийлэгдэхгүй. Харин Сүн улс бол Чин гүрний эртний дайсан билээ. Чин улс манай цэргийг нутгаараа өнгөрүүлж, дорнын нам дор газарт нэвтрэх боломж олгоно. Тэднээс бид шууд Кайфүн хотыг дайрах хэрэгтэй. Тэхээр Чин улс шилдэг цэргээ нийслэлээ хамгаалахаар өрнөөс татах болно. Энэ цэрэг мянган ли газрыг туулж нийслэлд ирлээ хүн хүч, агт морьд нь туйлдана. Тэр үед нь л та нар тэднийг бут цохих хэрэгтэй” хэмээн захижээ (*Михаэл Правдин 2005, т.153-154*). Эцгийнхээ захиас ёсоор “Тулуй монголын их цэргийг удирдаж Сүн улсын нутгаар дамжин дорно зүгт цөмрөн орсноор монгол цэрэг хоёр талаас нь дайрч орох тэр үед л Чин улсын хувь заяа шийдэгдэв (*Михаэл Правдин 2005, т.166*). Ингээд “монгол цэргүүд бүх Хятадыг 1234 оны морин жил эзлэн авчээ” (*Рашид-ад-Дин 2002b, т.25*). Дараа нь Тулуй насан нөхчиж, “**Сүбээдэй баатар** Туманган гүнжийг Өгөөдэй хаан өгч, өөрийн шадар жанжин, их цэргийг ерөнхийлөн захирах болжээ” (*Юань улсын судар, n.d.*).

**Найм.** Өгөөдэй хаан Эзэн богд Чингис хаан бурхан болоод арваад жил өнгөрсөн хойно Өгөөдэй хаан Перс, Иракийн Халифт улс, Бага Азийг эзлэхээр гурван түмэн цэргээ илгээжээ. Бас Сүбээдэй жанжныг Бат хааны хамт Европ хүртэлх агуу их байлдан дагуулалт хийснийг онцлох учиртай юм. Команчуудтай хүндхэн тулаан хийж ялалт байгуулсан ч Команчууд Котян хааныхаа хамт дутаасаар Оросын ван Мстиславыг бараадан очсон түүхтэй. Оросууд Команчуудыг ивээлдээ авч түүнтэй хамт монгол цэргийн эсрэг дайтсан юм. Сүбээдэй, Зэв нар Калка голын дэргэд

холбоотнуудын 90 000 орчим цэргийг өөрийн 20 000 орчим цэргээрээ бут ниргэсэн юм. Ингэхдээ буруулах тактикийг хэрэглэж, есөн өдөр дагуулан, санаачилгыг гартаа авч, оросын талын цэрэг сарнин цуврахад хэсэг хэсгээр нь бут цохисон ажээ.

#### Дүгнэлт:

Сүбээдэй баатар бол Их Монгол Улсын түүхэнд онцгой байр суурь эзэлсэн цэргийн гарамгай жанжин байжээ. Гадаад, дотоодын цэргийн түүхчид түүнийг Чингис хааны байлдан дагуулалтад онцгой үүрэг гүйцэтгэсэн гарамгай жанжин гэж дүгнэдэг нь дараах баримттай холбоотой байна. **Нэгд**, Чингис хаан олон жилийн дайн байлдааны практик, цэргийн байгуулалтын туршлагадаа тулгуурлан цэргийн жанжнуудаа сонгож, сурган хүмүүжүүлж, олон гарамгай жанжнуудын төрхийг тухайн үеийнхээ монголын нийгэм, цэрэг-улс төрийн байдалтай нөхцөлдүүлэн хэрэгжүүлж чадсаны үр дүнд дэлхий дахинаа суу алдраа дуурсгасан цэргийн гайхамшигт олон ноёд, баатрууд төрөн гарсан хүмүүсийн нэг Сүбээдэй баатар юм. **Хоёрт**, Чингис хааны “сэтгэлийн хүлгээр нөхөрлөсөн” нөхөд дотроос хамгийн урт насалж Их Монгол Улсын төрд зүтгэсэн нь Сүбээдэй бөгөөд Чингис хаан, Өгөөдэй хаан, Гүюг хааны үед болон Их хаад их хуралдайгаар хаан ширээнд суух хоорондын цаг хугацаа (1227-1229 онд Тулуй ханы эрх барьсан хоёр жил, 1241-1246 онд Дөргэнэ хатны эрх барьсан таван жил, 1248-1251 онд Огул Каймиш хатны эрх барьсан гурван жил)-нд нөлөө бүхий цэргийн жанжин байжээ; **Гуравт**, Энэ бүгд нь Сүбээдэй баатар цэргийн хэрэгт гүн суралцах, дадлагажих, ур чадвар нь нэмэгдэх нөхцөлийг бүрүүлж, дайснаа ялан дийлэхдээ мөрдөн мөшгих, гээг даран нэхэн байлдах, аялан дайтаж буулган авах стратеги, тактикийг гарамгай эзэмших хөшүүрэг болжээ; Сүбээдэй баатар монголын цэргийн урлагт бусад жанжнууд, хөлөг баатруудын хамт үнэнхүү ялан дийлэх ухааныг төгс эзэмшсэн, түүн дотроос мөрдөн мөшгих, гээг даран нэхэн байлдах, аялан дайтаж дайснаа буулган авах стратеги, тактикийг гарамгай жанжин байжээ.

#### Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл:

1. Алтан-Очир. 2020. *Богд Чингис хааны байлдааны бичиг*. “Удам соёл” ХХК. Улаанбаатар.
2. Д.Сайшаал. 1987. *“Чингис хааны товчоон” (Дээд, доод дэвтэр)*. Хөх хот.
3. Ж.Базарсүрэн, Д.Бадам, С.Гангааням, et al. 2014. *Цэргийн Нэр Томъёоны Тайлбар Толь*. Соёмбо Принтинг.
4. Михаэл Правдин. 2005. *Чингис хаан түүний өв*. Translated by Д. Моононцагаан. Адмон.
5. *Монголын нууц товчоо*. 2007. Сонгомол эх. Болорсудар.
6. Рашид-ад-Дин. 2002а. *Судрын Чуулган. I Боть*. (Орчуулсан Бат-Очир). Цоморлог төв ХХК.
7. Рашид-ад-Дин. 2002б. *Судрын чуулган. II боть*. Улаанбаатар.
8. Ренэ Груссе. 2004. *Чингис хааныхны монголчууд*. Франц хэлнээс орчуулсан Л.Бат-Очир. Цоморлог төв ХХК.
9. Х.Шагдар. 2019. *Энэ дэлхийд эгнэшгүй эцэг хүү гурван жанжин (Сүбээдэй, Урианхадай, Ачу)*. Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн хэвлэх үйлдвэр.
10. Х.Шагдар, Ж.Базарсүрэн, and Ц.Минжин. 2024. *Монгол цэргийн түүх : Хамаг*

*Монгол, Их Монгол Улсын цэрэг.* Боть: 1. Си Ти Пи Принтинг.

11. Ш.Паламдорж. 2006. *Их Монгол Улсын цэргийн урлаг.* Соёмбо Принтинг ХХК.
12. Ш.Паламдорж. 2022. *Цэргийн шинжлэх ухаан, Зэвсэгт хүчин.* Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл. Соёмбо принтинг.
13. *Юань улсын судар.* п.д. 210 дэвтрийн 121 дүгээр дэвтэр.

**Ашигласан сурвалж, судалгааны бүтээл:**

1. Ала-ад-Дин Ата-Мелик Жувейни. Дэлхийг байлдан дагуулагчийн түүх. Тэргүүн боть. /М.Бадамнямын орчуулга/ УБ., 2006 он. –262х; ISBN 99929-0-624-3;
2. Жиованни Дель Пано Карпини. Монголчуудын түүх ба Вильгельм Де Рубрук. Дорнод этгээдэд зорчсон минь. /ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс эрхлэсэн орчуулга/, УБ., 1998. – 254х;
3. Чжао Хун. Монгол татаарын Бүрэн тэмдэглэл. /Ж.Баясахын орчуулга/, УБ., 2005 он.
4. Пэн дая, Сюй Тин. Хар татаарын хэргийн товч. /Ж.Баясахын орчуулга/, УБ., 2005 он.
5. Марко Поло. Орчлонгийн элдэв сонин. УБ., 1987, - 304х;